



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 дугаар сарын 20 өдөр Дугаар 20 .

Хэрлэн сум

ХХ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын хурал Онцгой комиссын ажиллах журмын 1.8-д заасны дагуу цомхотгосон хэлбэрээр 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 15:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 77 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Дорнод аймгийн хилийн Эрээнцав боомтоор 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын 3 иргэн ОХУ-аас нэвтрэн орж ирсэн тухай мэдээллийг Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Мөнхтуяа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа, Гаалийн газрын дарга Б.Гэрэлт-Од, Хилийн 0275 дугаар ангийн захирагч, хурандаа Б.Гантөгс нарт:

1.1 Улсын Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр хуралдааны тэмдэглэлийн 1.1, 12 дугаар хуралдааны тэмдэглэлийн 8.1 дэх заалт, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газраас оруулсан саналын дагуу Эрээнцав, Ульхан боомтоор иргэдийн зорчих хөдөлгөөнийг түр хязгаарлахыг,

Хоёр. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзийд,

2.1 Улсын Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр хуралдааны тэмдэглэлийн 1.1, 12 дугаар хуралдааны тэмдэглэлийн 8.1 дэх заалт, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газраас оруулсан саналын дагуу Эрээнцав, Ульхан боомтоор зорчих зорчигчдын хөдөлгөөнийг түр хязгаарлах тухай саналыг албан бичгээр Улсын Онцгой комисс, Гадаад харилцааны яам, Улсын Онцгой комиссын шуурхай штабт хүргүүлэхийг,

Гурав. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа, Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Хилийн 0275 дугаар ангийн захирагч, хурандаа Б.Гантөгс нарт :

3.1. Дорнод аймгийн хилийн Эрэнцав боомтоор 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр ОХУ-аас нэвтэрсэн хилийн дунд байгаа Монгол Улсын 3 иргэнийг хүлээн авч тусгаарлалтын арга хэмжээг авч ажиллахыг тус тус үүрэг болголоо.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА М.БАДАМСҮРЭН

БҮСИЙН ТӨВ-ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ХОЛБОО, ЗАРЛАН МЭДЭЭЛЭЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН,  
АХМАД Э.ГАНЖИГҮҮР